



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгааны ажил болон мод, сөөг, зүлэг, нэг ба олон наст цэцэг тарилтын ажлын технологийн горимын мөрдөлтөд хяналт тавьж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, зөрчил, дутагдлыг арилгуулж ажиллахаар сонгон шалгаруулалтад шалгарсан Төрийн бус байгууллагуудтай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнг тооцож ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Гэрээгээр хүлээсэн үүргээ ханган биелүүлж, ажлаа сар бүр тайлагнаж ажиллахыг Нийслэлийн ногоон байгууламжийн хяналтын иргэний зөвлөл ТББ /О.Мэндсайхан/, Бид байгаль элч ТББ /Э.Нямхүү/, Монголын ландшафтын архитектур судлалын холбоо ТББ /Э.Болор/-д тус тус үүрэг болгосугай.

3. Ногоон байгууламжийн хяналтын Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг хавсралт ёсоор баталсугай.

4. Хяналтын ажлын үйл ажиллагааны зардал 118.320.485 /Нэг зуун арван найман сая гурван зуун хорин мянга дөрвөн зуун наян таван/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны ажлын захиалагчийн хяналтын 2 хувийн зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

. 1110300316

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны *Август* сарын *12* өдрийн
Ажээ тушаалын хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТЫН ТӨРИЙН БУС
 БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

д/д	Ажлын нэр, төрөл	Төрийн бус байгууллагын нэр, хариуцан ажиллах дүүрэг.	Үйл ажиллагааны нийт зардал /4-11-р сар/ /төгрөг/
1.	Хотын гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгаа, мод, сөөг, зүлэг тарилтын ажлын технологийн горимын мөрдөлтөнд хөндлөнгийн хяналт тавих, зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулах	1. "Монголын ландшафтын архитектур судлалын холбоо" ТББ Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт ажиллана.	38.420.485
		2. "Бид байгаль элч" ТББ Чингэлтэй, Хан-уул дүүрэгт ажиллана.	39.900.000
		3. "Нийслэлийн ногоон байгууламжийн иргэний хяналтын зөвлөл" ТББ Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт ажиллана.	40.000.000
	ДҮН	118.320.485	